



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2014.11.11

№	Ажил, арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь	Оноо
7.1. Хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд				
1	Аймгийн хэмжээнд 2013 онд иргэд олон нийтээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар авсан санал асуулгын дүгнэлт, өмнөх жилийн тайланд хийсэн үнэлгээ, АТГ-аас өгсөн чиглэл зөвлөмжинд тулгуурлан аймгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж баталгаажуулж мөрдөх	Иргэд олон нийтээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар авсан 2013 оны санал асуулгын дүгнэлт, өмнөх жилийн тайланд хийсэн үнэлгээ, Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл зөвлөмжинд тулгуурлан аймгийн Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг 2 бүлэг 32 ажил арга хэмжээтэйгээр боловсруулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100	
2	Авлигын эсрэг үйл ажиллагааг эрхлэх орон тооны бус зөвлөл байгуулан, гишүүдийг ажил үүргийн хуваарьтай ажиллуулж, сар бүр төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн явцыг хэлэлцэж холбогдох арга хэмжээ авах	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/05 тушаалаар орон тооны бус зөвлөлийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажил үүргийн хуваарь гарган ажилласан. 2014 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн А/56 тоот тушаалаар орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Орон тооны бус зөвлөл 2 удаа бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдаж ажил үүргийн хуваарийн дагуу хийсэн ажлаа зөвлөлдөн, харилцан мэдээлэл солилцсон.	90	
3	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, орон тооны бус зөвлөлийн ажлаас иргэд, байгууллага хамт олонд мэдээлэх ажлыг зохион байгуулах	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хийгдэж буй ажил, орон тооны бус зөвлөлийн ажиллагааны мэдээллийг сумдын Засаг даргын Тамгын газруудад хүргүүлж, олон нийтэд мэдээлэх ажиллагаа явуулсны дээр аймгийн хэмжээнд уламжлал болон нийт сум тосгоныг хамруулан зохион байгуулдаг “ Ээлтэй үйлчилгээг иргэн танд ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг,	100	


		<p>Жавхлант, Баянгол, Хушаат сум, Дулаанхаан тосгоны иргэдэд мэдээлэл өгч, санал солилцох ажил зохион байгуулсан.</p>		
<p>4</p>	<p>Иргэд, байгууллагын, Авлигын эсрэг хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн мэдлэг, мэдээллийг авах нөхцөл боломжийг хангах зорилгоор аймгийн цахим хуудас, аймгийн ЗДТГ-ын сар тутмын “Иргэн танаа” мэдээллийн сонинд тогтмол булан нээж ажиллуулах</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн мэдээлэл авах боломжоор хангаж, аймгийн “Selenge.gov.mn” цахим хуудсанд хууль тогтоомж, цаг үеийн хугацаат мэдээллүүдийг байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сар тутмын “Иргэн танаа” мэдээллийн сонинд авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээлэл авах утас, хаяг, холбогдох мэдээллийг тогтмол хэлбэрээр нийтэлдэг болсон. Уг сонины тусгай дугаарыг энэ оны 8-р сард авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээллээр бэлтгэн гаргаж, 17 сум, 6 тосгонд хуваарилан хүргүүлж, сурталчилсан. Аймгийн “Шинэ гэгээ” сонины 2014 оны 04,05/200,201/ дугаарт, төвийн “Зууны мэдээ” сонины 2014 оны 05-р сарын 30-ны өдрийн №125/4752/ дугаарт “Ил тод, ээлтэй хариуцлагатай үйлчилгээг иргэн бүрт” хэлэлцүүлгийн мэдээллийг тус тус нийтлүүлэн иргэд, олон нийтэд сурталчилсан.</p> 	<p>100</p>	
<p>5</p>	<p>Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн орон нутаг дахь хэрэгжилтэнд зөвлөн туслах үйлчилгээ зохион байгуулах</p>	<p>Сайхан, Хушаат, Жавхлант, Баянгол, Шаамар сум, Дулаанхаан, Номгон тосгон, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Тээвэр авто замын газар, Байгаль орчны газарт авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтээр зөвлөн туслах үйлчилгээ зохион байгуулсан.</p>	<p>100</p>	
	<p>Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл</p>	<p>Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаатай холбогдолтой сурталчилгаа мэдээллийн хуудас,</p>		

6	ажиллагаатай холбогдолтой сурталчилгаа мэдээллийн хуудас, материалын түгээлт, ашиглалтыг бүртгэлжүүлэх, хянан зохицуулах ажил зохион байгуулах	материалын түгээлтийг бүртгэлжүүлж, ашиглалтанд хэсэгчилсэн хяналт зохион байгуулсан. Тайлант онд “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” сургагч багшийн гарын авлага, “Нийтийн албан тушаалтны гарын авлага”, “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”, зэрэг мэдээллийн хуудас гарын авлага материалыг бүртгэлээр түгээсэн. Ашиглалтын хэсэгчилсэн хяналтыг Сайхан, Орхон, Түшиг сум, Стандартчлал хэмжил зүйн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэст явуулж зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.	100	
7	Аймгийн ИТХ, аймгийн Засаг даргаас 2014 онд шинээр боловсруулж гаргахаар төлөвлөсөн бодлогын болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох шийдвэрийн мэдээллийг аймгийн цахим хуудсаар нийтэд мэдээлэх	Тайлант онд шинээр боловсруулж гаргахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөвлөгөөнд тусгагдсан “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Сэлэнгэ аймгийн 2015-2018 оны төлөвлөгөө”, “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн талаар баримтлах бодлого”, “Ойгоос түлшний мод бэлтгэх, тээвэрлэх журам”, “Цахим сургууль-цахим сургалт хөтөлбөр”, “Амьдрах ухаан-ажлын байр хөтөлбөр”, “Орон сууц хөтөлбөр”, “Ээлжлэн тариалах систем хөтөлбөр”, “Иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ байршил батлах”, “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”, Хүдэр сумын эрүүл мэндийн төв, Баруунбүрэн, Цагааннуур сумдын сургуулийг нэрэмжит болгох, “Иргэний зөвлөл байгуулах”, “Архидалттай тэмцэх хөтөлбөр”, “Аймгийн концессын гэрээгээр гүйцэтгэх ажлын жагсаалт батлах тухай”, аймгийн Засаг даргын “Авилгын эсрэг үйл ажиллагааг сайжруулах зарим арга хэмжээний тухай”, “Төрийн үйлчилгээний лавлах баримт бичиг батлах тухай”, “Мэргэжил сонголт-2014 арга хэмжээ зохион байгуулах тухай”, “Ээлтэй үйлчилгээ иргэн танаа” арга хэмжээ зохион байгуулах тухай, “Ээлтэй үйлчилгээ-их бүтээн байгуулалтын жил болгох тухай”, “Ногоон Сэлэнгэ хөдөлгөөн өрнүүлэх тухай” зэрэг бодлогын нийт 21 шийдвэрийн мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн бусад эх үүсвэрээр нийтэд мэдээлэх арга хэмжээ авсан.	100	
8	Дээрх шийдвэрийн төслүүдийг аймгийн цахим хуудсанд байршуулах, олон нийтэд танилцуулах, санал авах ажил зохион байгуулах	Дээрх шийдвэрийн төслүүдээс “Архидалттай тэмцэх хөтөлбөр”, “Ээлжлэн тариалах систем хөтөлбөр”, “Иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ байршил батлах” “Аймгийн концессын гэрээгээр гүйцэтгэх ажлын жагсаалт батлах тухай”, Хүдэр		

		<p>сумын эрүүл мэндийн төв, Баруунбүрэн, Цагааннуур сумдын сургуулийг нэрэмжит болгох, “Иргэний зөвлөл байгуулах”, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Сэлэнгэ аймгийн 2015-2018 оны төлөвлөгөө”, “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн талаар баримтлах бодлого”, “Ойгоос түлшний мод бэлтгэх, тээвэрлэх журам”, “Төрийн үйлчилгээний лавлах баримт бичиг батлах тухай”, “Ээлтэй үйлчилгээг-иргэн танд” арга хэмжээ зохион байгуулах тухай, “Ээлтэй үйлчилгээ-их бүтээн байгуулалтын жил болгох тухай”, “Ногоон Сэлэнгэ хөдөлгөөн өрнүүлэх тухай” зэрэг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 11, аймгийн Засаг даргын 4 шийдвэрийн төслийг аймгийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд танилцуулах, санал авах ажлыг сумдын бүсийн төвүүдэд зохион байгуулсан. Шинээр боловсруулан гаргаж байгаа бодлогын баримт бичиг, нийтийн хамаарал бүхий шийдвэрийн төсөлд санал авах болон төрийн ажил үйлчилгээнд тавих хяналтанд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий <u>“Иргэдийн оролцоо – төрийн үйлчилгээ”</u> аймгийн хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2013 оны 12-р сарын 26 ны 136 дугаар тогтоолоор батлуулж тайлант онд хэрэгжилтийг эхлүүлэн ажиллаж байна.</p> 	100	
9	Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллага, хууль сахиулах, хяналт шалгалтын байгууллагуудаас зохион байгуулах хяналт шалгалтын төлөвлөгдсөн	Энэ онд төлөвлөгдсөн хяналт шалгалтын ажлуудаас олон нийтэд хамааралтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 5, Мэргэжлийн хяналтын газрын 12, Байгаль орчны газрын 4, Цагдаагийн газрын 5, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2 нийт 26 хяналт шалгалтын хугацаа, хамрах хүрээ, хариуцагчийн	100	


	ажлуудыг нийтэд мэдээлэх арга хэмжээ авах	мэдээлэл, хяналт шалгалтын дүн, шалгалтын мөрөөр авсан ажил арга хэмжээнүүдээс байгууллагуудын мэдээллийн самбар, цахим хуудсуудаар нийтэд мэдээлэгдсэн дүнтэй байна.		
10	Шилэн дансны тухай хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх бэлтгэл хангах, төсвийн орлого, зарцуулалт, зээл, тусламжийн хуваарилалтыг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	<p>Шилэн дансны хуулийн зорилго, агуулгыг таниулах, хэрэгжилтийн бэлтгэл хангах талаар мэдээлэл, үүрэг чиглэл өгөх арга хэмжээг, аймгийн төвд сумдын Засаг дарга, байгууллагуудын төсвийн шууд захирагч нарын, Сайхан суманд сум, тосгодын төрийн сангийн төлөөлөгчид, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын бүрэлдэхүүнтэй нэгдсэн байдлаар 2 удаа зохион байгуулж, сумдын бүсийн төвүүдэд бүсчилсэн байдлаар иргэд олон нийтэд 4 удаа мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан. Аймгийн болон Тамгын газрын төсвийн орлого, зарлага, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс иргэдэд олгосон тусламж, дэмжлэгийн хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг аймгийн цахим хуудас, төсвийн ил тод байдлын мэдээллийн самбарт сар, улирал тутам мэдээлж хэвшсэн. Засгийн газрын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, сумдын хөгжлийн сангийн зээлийн хуваарилалт, олголтын мэдээллийг аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт сар улирлаар байршуулах, аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн selenge.hudulmur.gov.mn цахим хуудсаар мэдээлэх ажлыг хэвшил болгон ажиллаж байна.</p>	100	




11	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь олон нийтэд мэдээлэх	<p>Аймгийн “Selenge.gov.mn” цахим хуудсанд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2013 оны санхүүгийн тайлан тэнцэлд Аудитын газраас хийсэн дүгнэлт, Мэргэжлийн хяналтын газраас хийсэн шалгалтын дүнг 2 удаа бүрэн эхээр нь байршуулж мэдээллийн самбар, төсвийн ил тод байдлын самбар, мэдээллийн цахим дэлгэцээр олон нийтэд мэдээлж таниулсан.</p>	100	
12	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийг олон нийтэд мэдээлэх	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын энэ оны 8, 9-р хуралдаанаар аймгийн төсөвт орсон тодотгол, нэмэлт өөрчлөлтийг иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн болон төсвийн ил тод байдлын самбарт, аймгийн “Selenge.gov.mn”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “khural.mn” цахим хуудаснаа байршуулж иргэд, олон нийтэд мэдээлсэн.</p>	100	
13	Тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалт, зарцуулалтыг олон нийтэд мэдээлэх	<p>Тайлант онд тус аймагт улсын төсвийн эрх шилжиж ирсэн 16 төсөл арга хэмжээний 9 тэрбум 586775,0 мянга, аймгийн төсвийн 33 төсөл арга хэмжээний 1 тэрбум 261842,6 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн 53 төсөл, арга хэмжээний 10 тэрбум 411737,6 мянга, Замын сангийн 22 төсөл, арга хэмжээний 421292,2 мянга, <u>нийт 21 тэрбум 681647,4</u> мянган төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөгдөж оны эхний 10 сарын байдлаар 9,2 тэрбум төгрөг зарцуулагдаад байгааг ажил арга хэмжээ бүрээр</p>	100	

		гаргаж, аймгийн “Selenge.gov.mn” цахим хуудаснаа байршуулж олон нийтэд хүргээд байна.		
14	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, хэрэгжилтийг олон нийтэд мэдээлэх	Тайлант онд тус аймагт Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрийн тусламжийн 165,0 сая төгрөгийн хөрөнгөөр Түшиг сумын 12 жилийн бүрэн дунд сургуулийн барилгад их засварын ажил хийгдсэн. Энэ тусламжийн хөрөнгийн хэмжээ, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын мэдээлэл, барилгын засварын ажлын гүйцэтгэлийг тухай бүрд нь орон нутгийн телевиз, сонин, мэдээллийн самбарт тавьж олон нийтэд ил тод мэдээлж ажилласан.	100	
15	Нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан зэргээс тэтгэвэр, тэтгэмж, зээл, тусламж авагчдыг олон нийтэд мэдээлэх	Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэдээллийг “selenge.hudulmur.gov.mn” , Халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллийг www.selenge.gov.mn цахим хуудас, сумдын Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбаруудаар нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн сангуудаас тэтгэвэр, тэтгэмж, тусламж авч буй 32875 иргэдийн, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл авсан 277 иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг олон нийтэд сар, улирлаар мэдээлсэн. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагч нийт 17222 үүнээс өндөр настны тэтгэвэр авагч 6138 иргэний мэдээлэл улсын хэмжээний цахим сүлжээнд бүрэн байршиж ашиглагдаж байна.	100	
16	Байгууллагаас олгож байгаа тусгай зөвшөөрлийн мэдээллийг, Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.7 дахь шалгууруудын дагуу олон нийтэд хүргэх	Аймгийн Засаг даргын Тамгын газраас Ерөнхий боловсролын сургуулийн сургалт эрхлэх, Сургуулийн өмнөх боловсролын сургалт эрхлэх, Хүн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, Эмийн сангийн үйлчилгээ эрхлэх, Архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын гэсэн 6 төрлийн тусгай зөвшөөрлийг зохих хууль тогтоомжийг баримтлан олгож байна. Тайлант онд дээрх ажлын хүрээнд шинээр 9 аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгож, 239 аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийн хугацааг сунгаж, 9 аж ахуйн нэгж, байгууллагад олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үйлчилгээг үзүүлсэн байна. Тусгай зөвшөөрлийг олгоход баримталдаг эрх зүйн акт, бүрдүүлэх баримт бичиг, төлбөртэй эсэх, хариуцагч албан тушаалтан зэрэг	100	

		<p>лавлагаа мэдээллийг энэ онд эмхэтгэн гаргасан Сэлэнгэ аймгийн засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгуулагуудаас үзүүлж байгаа “Төрийн үйлчилгээний лавлах” номонд тусган олон нийтэд ашиглуулж эхэлсэн.</p>		
17	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.8 дахь шалгууруудын дагуу зохион байгуулах</p>	<div data-bbox="954 268 1957 523" data-label="Image"> </div> <p>Аймгийн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2014 оныг “Төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх жил” болгон зарлаж түүнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “15 багц ажлын чиглэл”-ийг боловсруулан гаргаж хэрэгжилтийн явц үр дүнг тооцон ажиллаж байна.</p> <p>Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын сул орон тооны захиалгыг нэгтгэн эхний 10 сарын байдлаар нийт 46 албан тушаалын сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн “<u>csc.gov.mn</u>” цахим хуудсанд байршуулан нийтэд ил тод мэдээлж, төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан.</p> <div data-bbox="954 791 1402 1117" data-label="Image"> </div> <p>Төрийн байгууллагын удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 2014 оны эхний 10 сарын байдлаар Хэрх тосгоны цэцэрлэгийн эрхлэгч, Мандал сумын 2, 3 дугаар сургуулийн захирал, Сант сумын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах 4 ажлын байрны зарыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршуулан зарлаж 2 удаа Төрийн албаны зөвлөлд хүсэлт гарган цахим хэлбэрээр зохион байгуулсан.</p>	100	

		<p>Төрийн албаны мэргэшлийн шалгалтын явцыг иргэд, олон нийтэд нээлттэй болгох зорилгоор улсад анх удаа телекамерийн хяналтын систем нэвтрүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлсэн.</p> 		
18	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.9 дэх шалгууруудын дагуу зохион байгуулах</p>	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Барилга хот байгуулалтын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёл, спорт аялал жуулчлалын яам, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яамны захиалгатай 12 тендерийн урилгыг “Зууны мэдээ” сонины 2014 оны 3-р сарын 25, 26, 31, 4 дүгээр сарын 2, 9, 5-р сарын 2, 6-р сарын 20, 7-р сарын 2, 9-р сарын 23-ны өдрийн дугааруудад, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 4 тендерийн урилгыг “Зууны мэдээ” сонины 2014 оны 1-р сарын 28, 3-р сарын 28, 5-р сарын 2, 7-р сарын 24-ны өдрийн дугааруудад, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх 20 ажлын тендерийн урилгыг “Зууны мэдээ” сонины 2014 оны 3-р сарын 3, 25, 4-р сарын 29, 5-р сарын 23, 8-р сарын 11, “Үнэн” сонины 2014 оны 3-р сарын 3-ны дугааруудад тус тус нийтлүүлж олон нийтэд мэдээлсэн.</p>	100	
19	<p>Ажилтнуудын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж мөрдөх</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/45 дугаар тушаалаар ажилтнуудын “Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх ажлын хэсэг” томилон ажиллуулж, нийт 38 ажилтны ажлын байрны тодорхойлолтыг, 42 ажилтны хөдөлмөрийн гэрээг шинэчлэх арга хэмжээг авч мөрдүүлсэн.</p>	100	
20	<p>Төрийн бус байгууллагатай тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулах, үр дүнг тооцох, олон нийтэд мэдээлэх</p>	<p>Аймгийн Засаг даргаас 2014 онд аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Авлигаас урьдчилан сэргийлэх Төрийн бус байгууллагын сүлжээ, Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэг, Эмэгтэйчүүдийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Барселон олимпийн зөвлөл, Уяачдын холбоо, “Сэлэнгэ амьдрах сайхан” ТББ, Хөдөлмөр нийгмийн зөвшилт 3 талт салбар хороо, Хөгжлийн</p>	100	

		<p><i>бэрхшээлтэй иргэдийн Сэлэнгэ аймаг дахь салбар, Ахмадын хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар хороо зэрэг 12 төрийн бус байгууллагатай тодорхой ажил үүргийг гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж үйл ажиллагаанд нь нийт 30.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж үр дүнг улиралаар тооцон ажиллаж байна. Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхэд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд тайлант онд төвийн “Зууны мэдээ” сонин, орон нутгийн “Сэлэнгийн мэдээ”, “Шинэ гэгээ” сонин, “Миний Монгол”, “Таны Сэлэнгэ” КТВ, “Өргөн сэлэнгэ” FM болон телевизийн чиглэлийн 3 чөлөөт уран бүтээлчидтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, аймгийн төсвөөс үйл ажиллагаанд нь 12.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж үр дүнг нь улирал тутам тооцон ажиллаж байна.</i></p>			
21	<p>Байгууллагын хэмжээнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.11 дэх шалгууруудын дагуу зохион байгуулах</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газарт мөрдөх ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг боловсруулах, аймгийн Засаг даргын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн, зөвлөлийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд баримтлах зарчмыг шинээр тусган мөрдөх зэрэг арга хэмжээг тайлант онд аваад байна.</p>		100	
22	<p>Аймгийн Засаг дарга, Тамгын газраас гаргаж байгаа шийдвэрийн ил тод байдлыг хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.13 дахь шалгууруудын дагуу зохион байгуулах</p>	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын тогтоол, захирамж, тушаалыг тухай бүр аймгийн албан ёсны цахим хуудасны “Хууль эрх зүй” цэсний Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, “Ил тод байдал” цэсний Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт дотор байршуулж иргэд, олон нийтэд мэдээлж ажилласан.</p>		100	
23	<p>Иргэдийн санал өргөдөл гомдолтой холбогдсон ажил үйлчилгээг Төрийн</p>	<p>Иргэдийн санал өргөдөл гомдолтой холбогдсон ажил үйлчилгээг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх</p>			

	<p>байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.14 дахь шалгууруудын дагуу зохион байгуулах</p>	<p>аргачлал, шалгууруудын дагуу зохион байгуулах хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газарт иргэд олон нийтийн санал хүсэлтийг хүлээн авах 7036-1111 шууд утас ажилуулах, энэ ажлыг хариуцсан ажлын байр бий болгох арга хэмжээ авсан. Орон нутгийн “Миний монгол” телевизэд “Иргэдээ сонсьё” шууд нэвтрүүлгийн тогтмол цагтай болж, аймгийн удидлага, төрийн үйлчилгээний байгууллагууд оны эхнээс баталж олон нийтэд мэдээлсэн хуваарийн дагуу уг нэвтрүүлэгт оролцож иргэдийн үгийг сонсож, авсан арга хэмжээгээ хариу мэдээлдэг болоод байна. Тайлант онд аймгийн Засаг даргын тамгын газарт 118 өргөдөл, гомдол ирсэн. Үүний 58 өргөдлийг бичгээр, 48 санал, хүсэлтийг 7036-1111, 7036-3535 шууд утсаар тус тус хүлээн авч хугацаанд нь бүрэн шийдвэрлэж хариуг өгсөн.</p> <p><u>Дээрх өргөдөл, санал, хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл:</u></p> <table border="0"> <tr> <td>Буцалтгүй тусламж хүсэх тухай өргөдөл</td> <td>10</td> <td>8 %</td> </tr> <tr> <td>Ажилд орох тухай өргөдөл</td> <td>10</td> <td>8 %</td> </tr> <tr> <td>Тусгай зөвшөөрөл хүссэн талаарх өргөдөл</td> <td>9</td> <td>8 %</td> </tr> <tr> <td>Төрийн байгууллага, албан тушаалтны тухай гомдол</td> <td>14</td> <td>12 %</td> </tr> <tr> <td>Бусад асуудлаар гаргасан өргөдөл</td> <td>75</td> <td>64 % тус тус байна.</td> </tr> </table> <p>Орон нутгийн телевизийн 3 удаагийн шууд нэвтрүүлэг дээр гарсан 26 санал хүсэлтийг барагдуулж хариуг мэдээлэх ажил хийгдээд байна.</p> <p>Засгийн газрын 1111 төвөөс өнгөрсөн хугацаанд Сэлэнгэ аймагт холбогдолтой нийт 25 санал хүсэлт шилжүүлэн ирүүлснийг хугацаанд нь шийдвэрлэж хариуг мэдээлсэн.</p>	Буцалтгүй тусламж хүсэх тухай өргөдөл	10	8 %	Ажилд орох тухай өргөдөл	10	8 %	Тусгай зөвшөөрөл хүссэн талаарх өргөдөл	9	8 %	Төрийн байгууллага, албан тушаалтны тухай гомдол	14	12 %	Бусад асуудлаар гаргасан өргөдөл	75	64 % тус тус байна.	100	
Буцалтгүй тусламж хүсэх тухай өргөдөл	10	8 %																	
Ажилд орох тухай өргөдөл	10	8 %																	
Тусгай зөвшөөрөл хүссэн талаарх өргөдөл	9	8 %																	
Төрийн байгууллага, албан тушаалтны тухай гомдол	14	12 %																	
Бусад асуудлаар гаргасан өргөдөл	75	64 % тус тус байна.																	
24	<p>Авлигын эрсдэл, авлига гарах боломжийг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй ажил, асуудлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.15 дахь шалгууруудын дагуу зохион байгуулах</p>	<p>“Ил тод, ээлтэй хариуцлагатай үйлчилгээ” сэдэвт Авлигын эсрэг олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийн шийдвэр, санал асуулгын дүнг үндэслэн авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг аймгийн хэмжээнд гаргасан, Авлигатай тэмцэх газраас хийсэн шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулж аймгийн болон Шаамар, Жавхлант, Алтанбулаг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын гаргасан зарим захирамж, тушаалуудыг хүчингүй болгуулах ажлыг зохион байгуулсан, Шаамар, Баянгол,</p>	100																



		Хүдэр, Ерөө сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын захирамжаар сахилгын шийтгэл ногдуулсан. Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 3 захирамж, 1 төлөвлөгөө гаргаж, 6 албан тоотыг сум, хэлтэс, албад хүргүүлж зөрчлийг арилгуулах ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулж, тайлан мэдээг тухай бүр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажилласан.		
25	Авлигатай тэмцэх газраас гаргасан шийдвэрийг биелүүлэх ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.17 дахь шалгуурын дагуу зохион байгуулах	Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 01/2951, 01/3461 тоотой ирүүлсэн “Аймгийн шагналын журам”, “Нийтийн албан тушаалтнуудын дотоодын томилолтын зардал”-тай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг хэрэгжүүлж аймгийн Засаг даргын А/150 тоот захирамжаар “Шагналын журам”-ыг шинэчлэн, аймгийн Засаг даргын 2014 оны 1/405, 1/406 тоотой томилолтын зардалд анхаарах асуудлаар сум, хэлтэс, албадад үүрэг өгч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас зөрчил арилгуулахаар ирүүлсэн албан тоотын дагуу тусгай зөвшөөрөл, тендер, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах ажлыг Хүдэр, Ерөө, Шаамар, Алтанбулаг, Сүхбаатар, Жавхлант, Баянгол сумдад зохион байгуулж, Шаамар, Баянгол, Хүдэр, Ерөө сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын захирамжаар сахилгын шийтгэл ногдуулж, зөрчлийг тухай бүр арилгаж, энэ талаар Авлигатай тэмцэх газарт тухай бүрт нь тайлагнаж ажилласан.	100	
7.2. Авлигатай тэмцэх санал, санаачилгын хүрээнд				
26	Нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээнд иргэд олон нийтийн санал авч харгалздаг арга хэлбэрээ ухаалаг төрийн зарчимд нийцүүлэн сайжруулж мөрдөх	Аймгийн хэмжээнд 2012 оноос эхлэн хэрэгжүүлж буй төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээнд иргэдээс “Санал асуумжийн хуудас”-аар санал авч харгалздаг арга ажиллагаандаа энэ онд ухаалаг төрийн зарчимд нийцүүлсэн зарим өөрчлөлт хийсэн. Энэ онд уламжлалын дагуу бүх сум, тосгодыг хамруулан зохион байгуулагдсан <u>“Ээлтэй үйлчилгээ – иргэн танд”</u> нэгдсэн арга хэмжээгээр нийт 1250 иргэнээс 12 байгууллага, тэдгээрт ажиллаж буй албан хаагчдын үйл ажиллагаанд санал асуумжаар үнэлгээ авч нэгтгэн мэдээлж, жилийн ажлын үнэлгээнд харгалзахад бэлэн болгоод байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт 2012 оноос нэвтрүүлж буй	100	


Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2008 стандартын хэрэгжилтийн явцад Герман-Монголын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгээр Чанарын удирдлагын тогтолцооны тэргүүлэх аудитор Б.Гэрэлээр хөндлөнгийн аудит хийлгэж, гаргасан дүгнэлт зөвлөмжийн дагуу хийх ажлаа төлөвлөн хэрэгжүүлж, түүндээ дотоод аудитийн баг томилон ажиллуулж үр дүнгээ хамт олноороо хэлэлцэх арга хэмжээ авсан. Аймгийн Засаг даргын Тамгын газар **“Үйл ажиллагааны нийцлийн аудит”**–ыг аймгийн Аудитийн газраар хийлгэж, гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авсан. Дээрх аудит, хяналт шалгалтуудаар авлигын зөрчил илрээгүй.

Аймгийн Засаг даргын 2014-03-31-ний өдрийн “Авлигын эсрэг үйл ажиллагааг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/116 дугаар захирамж гаргаж нутгийн захиргааны байгууллага, төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааг ил тод болгох, үнэлгээнд иргэд олон нийтийн санал авч харгалздаг арга хэлбэрт шилжихийг үүрэг болгосон. Энэхүү ажлын хүрээнд




Монгол Улсын Ерөнхийлөгчийн **“Том төрөөс Ухаалаг төр лүү”** санаачилга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, сумдын хэмжээнд ухаалаг засаглал, иргэн төвтэй төрийн үйлчилгээний зарчмыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар харилцан мэдээлэл солилцох, туршлага судлах зорилгоор сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын **“Ухаалаг төрийн бодлого Сэлэнгэ аймагт”** сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Зөвлөлдөх уулзалтаар сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Том төрөөс Ухаалаг төр лүү” бодлогыг сум орон нутагтаа хэрхэн хэрэгжүүлж буй болон Засгийн

		<p>газрын 2014 оны “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147, 326 дугаар тогтоол, болон Төсвийн тухай хууль, түүнтэй холбогдон гарсан дүрэм, журмуудын хэрэгжилт цаашид төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх талаар анхаарах асуудлуудыг тодотгож, харилцан санал солилцож ажилласан.</p> 		
27	<p>Бүрдүүлэх баримт бичиг, хариуцах байгууллага, албан тушаалтан зэрэг мэдээллийг агуулсан “Төрийн үйлчилгээний лавлах” –ыг эмхэтгэн гаргах</p>	<p>Орон нутгийн хэмжээнд төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагуудаас үзүүлдэг үйлчилгээний нэр төрөл, баримталдаг эрх зүйн акт, бүрдүүлэх баримт бичиг, төлбөртэй эсэх, хариуцагч албан тушаалтны утас, байршил зэрэг лавлагаа мэдээлэл бүхий, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 байгууллагын 240 ажил үйлчилгээг хамруулсан “Төрийн үйлчилгээний лавлах” баримт бичгийг боловсруулан гаргаж, аймгийн Засаг даргын энэ оны 112 дугаар захирамжаар баталгаажуулан ном болгон 500 хувиар хэвлүүлж, иргэд олон нийтийн хэрэгцээнд шилжүүлсэн.</p> 	100	

28	<p>Авлигын эсрэг төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтран ажиллах гэрээ байгуулж үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх Төрийн бус байгууллагын сүлжээнд аймгийн Засаг даргаас 2014 онд 1.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, сүүлийн 3 жилд хийсэн ажлын тайланг <u>“Ил тод, ээлтэй, хариуцлагатай үйлчилгээ”</u> сэдэвт</p>  <p>авлигын эсрэг олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр нийтэд мэдээлүүлэх ажлыг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал санаачлагуудыг төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.</p>	100	
29	<p>Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2014 оныг “Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйн жил” болгон зарлаж дэвшүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн мэдлэг баяжуулах сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, зөвлөмж гаргах</p>	<p>Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2014 оныг <u>“Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйн жил”</u> болгон зарлаж дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн <u>“Ээлтэй үйлчилгээ, эелдэг харилцаа”</u>-г төлөвшүүлэх арга хэмжээний тухай А/188 дугаар захирамжийг гаргаж хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажилласан.</p>	100	

		<p>Аймгийн төвийн төрийн захиргааны албан хаагчдын сургалт, семинарыг Сүхбаатар суманд, сумдын бүсчилсэн сургалт, зөвлөгөөнийг Хушаат, Баянгол, Жавхлант, Ерөө, Хүдэр</p>  	<p>сум, Бугант тосгонд тус тус зохион байгуулж нийтдээ 1000 гаруй төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдыг хамруулсан.</p> 		
30	Тамгын газрын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцооны Аудитын баг, төсвийн дотоод аудитаар аудит хийлгэж, холбогдох арга хэмжээ авах	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газарт Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд чанарын удирдлагын тогтолцооны дотоод аудит бэлтгэх ажлын хүрээнд Германы хамтын ажиллагаа, Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага хөтөлбөртэй хамтран Чанарын удирдлагын тогтолцооны дотоод аудиторын сургалтаар 21 дотоод аудитор бэлтгэж ажилласан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг сайжруулах ажлын хүрээнд аудитор Б.Гэрэлтэй хамтран дотоод аудит хийж, аудитоор илэрсэн зөрчлүүдийг арилгуулах арга хэмжээ авсан.</p>	100		

		Тамгын газрын өнгөрсөн жилийн санхүүгийн тайлан тэнцэлд аймгийн Аудитийн газраар аудит хийлгэж дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			
31	Авлигатай тэмцэх газраас явуулсан Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээ дүгнэлтээр илэрсэн зөрчил дутагдлыг залруулах ажил зохион байгуулах	Төрийн байгууллагуудаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлалын дагуу хийсэн “Шинжээчдийн баг” -ийн үнэлгээтэй холбоотой Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн “Үнэлгээний дүнгийн тухай” 01/781 албан тоотоор ирүүлсэн 17 сөрөг арга хэмжээг арилгах ажлыг зохион байгуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж, хийсэн арга хэмжээний мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.		100	
32	Иргэд, байгууллагаас авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбогдуулж ирүүлсэн гомдол, мэдээллийг барагдуулах	Баянгол, Шаамар сумын Засаг дарга нарын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг зөрчсөн талаар иргэдээс гаргасан гомдлыг барагдуулж Шаамар, Баянгол сумын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын 2014 оны А/319, А/320 дугаар захирамжаар сахилгын арга хэмжээ авч ажилласан.		100	

Тайланг нэгтгэн боловсруулсан:

Хууль зүйн хэлтсийн дарга

Ч.Даваадорж

Авлига, хүний эрхийн асуудал хариуцсан ажилтан
Эрх бүхий албан тушаалтан

Л.Баярсүрэн

Хянасан:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Ө.Сувдаа